



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/ИИ.

Хэрлэн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь хэсэг, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар тогтоолын 07 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар батлагдсан Дархан суманд хууль бус гар аргаар байгалийн өнгөт чулуу түүсэн иргэдийн нөлөөгөөр эвдэрсэн 10 га газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажлын худалдан авах ажиллагааны захиалагчийн эрхийг Дархан сумын Засаг даргын Тамгын газарт шилжүүлсүгэй.

2. Тус худалдан авах ажиллагааг батлагдсан төсөвт багтаан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн дагуу зохион байгуулж тайлагнахыг Дархан сумын Засаг дарын Тамгын газрын даргад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА